

Title	Монгол богино хэлбэрийн шүлгээр дамжуулан монголчуудын ахуй, сэтгэлгээний онцлогийг таниулах нь
Author(s)	Magsarjav, Bayarsaikhan
Citation	外国語教育のフロンティア. 2018, 1, p. 7-13
Version Type	VoR
URL	https://doi.org/10.18910/69774
rights	
Note	

Osaka University Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

Osaka University

Монгол богино хэлбэрийн шүлгээр дамжуулан МОНГОЛЧУУДЫН АХУЙ, СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГИЙГ ТАНИУЛАХ НЬ

モンゴル短型詩によるモンゴル人の様式・思考特徴の紹介

MAGSARJAV, Bayarsaikhan

要約

モンゴルには、古来短型詩の伝統があり、例えば、口承文芸に二ないしは三、四行詩から成るなぞなぞやことわざ、さらに世界の三つ、四つなどの伝統的ジャンルがある。さらに書写文学にも四行詩から成る教訓詩が少なからずある他、二行詩から成る祝詞や讃歌も一種の短型詩と見なすことができる。

本稿では、モンゴルに日本の俳句が伝わった歴史とその現状、さらには日本の俳句の影響を受けて独自に発展した“モンゴル版俳句”、すなわちхайц（ハイツ）の概要を紹介するとともに、モンゴル人の様式・思考特徴が色濃く反映されたхайцを、今後日本のモンゴル語教育に導入することにより、それがモンゴル文化紹介の有効な手段となりうることを説いたものである。

キーワード：モンゴル、短型詩、俳句、ハイツ

1. Оршил

Аль ч үндэстний хэлийг сурч, судалж буй хүнд тухайн ард түмний түүх, ёс заншил, газар нутаг, амьдрал ахуйн талаар зохих хэмжээний суурь мэдлэг зайлшгүй хэрэгтэй. Хэл бол соёлын толь гэдэг. Хамгийн энгийн өдөр тутмын үг хэллэгийн цаана ч соёлын тусгал байдаг. Иймд гадаад хэлийг зааж сургах хичээлүүд нь тэр хэлээр ярих, сонсох, унших, бичих дадлыг эзэмшүүлэх ялдамд тухайн хэлтэн ард түмний талаарх мэдлэгийг их, бага ямар нэг хэмжээгээр олгож байдаг. Осака их сургуулийн монгол хэлний ангийн сургалт нь хэлний хичээлийн агуулгад хэл соёлын шүтэлцээг анхаарч тусгахын зэрэгцээ оюутнуудын Монгол орон ба монголчуудын талаарх мэдлэгийг ахиулахад чиглэсэн Монголын түүх, Монголын уран зохиол зэрэг тусгай хичээлийг оруулдаг билээ. Үүнчлэн 3-4 дүгээр ангийн оюутны сонгон судалж үзэх хичээлүүдийн үндсэн зорилго нь монгол хэлний мэдлэг боловч, уншиж танилцах сэдвийн агуулга, харилцан яриагаар дамжуулан оюутны Монгол орон судлалын мэдлэгийг алхам алхмаар дээшлүүлэх зорилгыг нэгэн адил чухалчилж байгаа юм. Тухайлбал, Монгол хэл III хичээлд Монголын уран зохиол, аман зохиолын олон төрөл зүйлээс сонгон

уншуулж, холбогдох тайлбар мэдээллийг багш хэлж танилцуулдаг бөгөөд хичээлийг унших, сонсох, бичих, харилцан ярих холимог хэлбэрээр төлөвлөдөг юм.

Тус өгүүлэлд дурдсан хичээлээр монгол богино хэлбэрийн шүлгээс сонгон унших дашрамд, тэдгээр шүлэгт монголчуудын ахуй, сэтгэлгээний онцлог хэрхэн тусгасныг таниулах боломжийг монгол маягийн хайку шүлгээр төлөөлүүлэн дурдах болно.

2. Монгол богино хэлбэрийн шүлгийн тухайд товчхон

Монголчуудын утга зохиолд бусад үндэстний нэгэн адил богино хэлбэрийн шүлгийн уламжлал бий. Монгол ардын аман зохиолд хоёр ба гурав, дөрвөн мөрөөр шүлэглэсэн оньсого, зүйр цэцэн үгс болон ертөнцийн гурав, ертөнцийн дөрөв зэрэг төрөл зүйл ихэд тархан уламжилсаар ирсэн байна. Бичгийн зохиолд дөрвөн мөрт сургаал шүлэг цөөнгүй уламжилжээ. Мөн монголчууд хос уянга, хош холбоо гэх зэргээр нэрийддэг хоёр мөрт ерөөл, магтаалын шинжтэй бэлгэ дэмбэрлийн үгсийг тухайн нөхцөл байдалд тохируулан өөрсдөө зохион хэрэглэсээр ирснийг богино хэлбэрийн шүлэг гэж болох юм. Үе үеийн Монголын яруу найрагт богино хэлбэрийн 4 мөрт шүлэг онцгой байр суурьтай байсаар ирсэн. Сүүлийн үед монгол маягийн хайку шүлгийн хэд хэдэн ном хэвлэгдэн гарав.

2.1 Монгол маягийн хайку шүлгийн тухай

Монголын яруу найрагчид Японы хайку шүлэгтэй 1966 оны үеэс анх танилцаж байжээ. Монголын шилдэг яруу найрагчдын нэг Б.Явуухулан 1966 онд “Японы хайку хэлбэрийн шүлгийн тухай” хэмээх өгүүлэл бичсэн нь “Цог” сэтгүүлийн 1966 оны №1 дүгээрт болон зохиогчийн “Яруу найраг - миний амьдрал” номд, хожим түүвэр зохиолынх нь 2 дугаар ботид нийтлэгджээ. Б.Явуухулан энэ өгүүлэлдээ хайку шүлгийн тухай танилцуулж, Мацуо Башё (松尾芭蕉), Чиё-ни (千代尼), Масаока Шики (正岡子規), Такараи Кикаку (宝井其角), Хаттори Рансэцу (服部嵐雪), Накагава Оцую (中川乙由), Мацукура Ранран (松倉嵐蘭), Эса Шоохаку (江左尚白) нарын шүлгээс орчуулан жишээ болгосон байна. Тэр бээр 1967 онд “Япон хайку маягаар бичсэн дөрвөн улирлын шүлэг” хэмээн улирал тус бүрээр нэрлэсэн 4 шүлэг бичсэн юм. Монголын хайкугийн холбооны ерөнхийлөгч Ү.Хүрэлбаатарын дүгнэснээр Б.Явуухулангийн эдгээр шүлэг нь «Монголын орчин үеийн утга зохиолд хайку шүлгийг татан оруулсан чухал эхлэл байсан юм. 1974 онд зохиолч, орчуулагч Ж. Лхагва “Японы яруу найраг” ном хэвлүүлж түүнд 85 яруу найрагчийн танка, хайку болон орчин үеийн шүлгийг орчуулсан нь хайку шүлэг монголд дэлгэрэх бас нэгэн давалгаа болсон юм. Мөн яруу найрагч Б. Лхагвасүрэнгийн “Уянгын тойрог” номд орсон “Шувууны мөр” хэмээх бүлэг хайку шүлэг 80-аад оны залуу яруу найрагчдад үлгэр болж байв» (Хүрэлбаатар Ү, 2015).

Эдүгээ Монголд “Хязгаараас цааш” зэрэг хайку шүлгийн гурван бүлгэм идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2015 оны 3-р сард Монголын хайкугийн холбоо байгуулагдаж, олон улсын хайку шүлгийн кукай наадмыг зохион байгуулсан байна. Монгол хайку шүлгийн номуудаас дурдвал: Л. Хүрэлбаатарын “Чөдөр гурвалжин”, “Тархины фитнес”, “Гандирсан”, С.Билигсайханы “Өвс өвсөөн үнэснэм”, “Хязгаараас цааш” бүлгийн “Мэдрэхүйн байгаль” шүлгийн түүвэр зэрэг болно. Миний бодлоор монгол хайку маягийн шүлгийг ерөнхийд нь хоёр хэсэг ангилж болохоор байна. Үүнд:

Нэг дэх нь, зохиогчийн үзэл хандлагаас ангид, өөрөөсөө гарч, хайкугийн үндсэн зарчмуудыг баримталж бичсэн шүлгүүд. Ийм шүлгүүд нь байгаль, улирлыг илэрхийлсэн үг- киго бүхий, ажиглалт туршлага дээр төвлөрч бясалгаж бичсэн, нарийн мэдрэмж бүхий зураглал байдаг. Жишээ нь Б. Явуухулангийн шүлгүүдийг энд дурдаж болно.

Хоёр дахь нь, зохиогчийн үзэл хандлага, дотоод ертөнцийг далд утгаар илэрхийлсэн, хайкугийн дүрэмд баригдаагүй шүлгүүд юм. Ийм шүлгүүд нь өөр лүүгээ орж, өөрийгөө эрэлхийлсэн байдаг. “Хязгаараас цааш” бүлгийнхэн хайку маягийн ийм чөлөөт шүлгээ “ХАЙЦ” шүлэг гэж нэрлээд «Хайцын хамгийн чухал дүрэм бол сэрэл мэдрэмжийн онцлог байдал, түүний философлог чанар юм. Хайц зохиогч гүн ухааны үзлээ, зүрх сэтгэл, шаналал, сэрэл мэдрэмжтэй хослуулан бичдэг. Өөрөөр хэлбэл хүний философи үзэл, сэрэл мэдрэмжийн цогц нийлбэр юм. Мөн энэ нь хүн дотоод мөн чанараа нээж, өөрийгөө олох эрэл хайгуул юм» (Надалсүрэн П, 2013) хэмээн томъёолж байна. Зарим ийм шүлэгт киго ашиглан байгаль, бодит байдлыг зураглахын хамт хувь хүний сэтгэлийн өнгө аясыг давхар илэрхийлсэн байхад, зарим энэ төрлийн шүлэгт киго ашиглалгүй, санаа, мэдрэмжээ илэрхийлсэн байх ажээ. Товчоор хэлбэл, “хайц” шүлэг нь японы хайку шүлэг шиг 3 мөрт богино хэлбэрээр бичдэг боловч, монгол шүлгийн уламжлал, онцлогийг шингээсэн далд утгат шүлэг юм. Тус өгүүллийн зорилго утга зохиол судлалд үл хамаарах тул хайку шүлгийн орчин дахь уламжлал шинэчлэл хийгээд бусад асуудлыг хөндөлгүй, монгол маягийн хайкугийн талаарх товч мэдээллийг үүгээр эцэслэе.

3. Монгол хэлний хичээлээр “хайц” шүлэгтэй танилцуулах нь

Оршилд өгүүлсэнчлэн сонгож уншуулдаг Монголын утга зохиол, аман зохиолын олон төрөл зүйлийн төлөөлөл эхүүдтэй харьцуулахад “хайц” хэлбэрийн богино шүлэг нь дараах онцлогтой юм. Үүнд, хайку ба хайц шүлгийг уран гоё, ховор чамин үг хэллэгээр бус, энгийн нийтэд ойлгомжтой цөөн үгээр бичдэг. Энэ нь суралцагчдын хэлний мэдлэгийн

түвшинд тохирох давуу талтай. Мөн япон оюутнууд өөрийн үндэсний хайку хэлбэрийн шүлгийн талаар бэлэн мэдлэгтэй байдаг учраас монгол маягийн хайку шүлэгтэй танилцах, харьцуулж үзэхэд дөхөмтэй. Монгол маягийн хайку шүлэг нь нэг талаар Япон Монголын соёлын харилцаа, Монгол утга зохиол дахь Японы соёлын нөлөөний бодит жишээ учраас сонирхолтой. Нөгөө талаар монгол маягийн хайку шүлэгт Монгол нутаг, нүүдэлч малчдын сэтгэлгээ, ахуй байдал туссан байдаг нь багшийн тайлбар яриагаар дамжуулан энэ талын мэдлэг олгох ач холбогдолтой юм.

Хичээлд уншуулах шүлгийг сонгохдоо эдгээр онцлогийг хэр тусгасныг харгалзан үзэх нь зүйтэй. Эхлээд шүлгийг уншуулж, мэдэхгүй шинэ үгсийг таниулсны дараа харилцан яриа, асуулт хариулт өрнүүлэх байдлаар хичээлийг явуулахад хайку хэлбэрийн шүлэг тохиромжтой. Учир нь хэзээ, хаана, яагаад, ямар учраас гэсэн эргэцүүлэлгүйгээр хайкуг тайлан ойлгож болохгүй. Мэдээжээр асуулт хариулт, тайлбарт аль болох ойлгомжтой, хялбар үгийг эрэлхийлэх нь чухал.

3.1 Монгол маягийн хайку (хайц) шүлгийг тайлж ойлгуулах зарим жишээ.

Хайку маягийн шүлгийг яаж ч тайлбарлаж болно гэсэн үг байдаг. Хэдийгээр хайц шүлэгт нэг л бодол санаа, тайлбарыг тулгаж хашиж болохгүй боловч, монгол хүмүүсийн нийтлэг сэтгэлгээ, үнэлэмжийн зүйлийг тайлбарлах боломжтой.

Хөвчид уянгалах

Хөхөөн дуунд

Хөрсөн өндөг бүлээцнэ...

Энэ шүлэгт хөхөөн дуу гэдэг үг зун цагийг төлөөлж байна. Монголын хангай нутгийн ой хөвчид хөхөө шувуу элбэг. Хөвчид уянгалах гэдэг үгээр хүний сэтгэлд зохистой, урин дулаан цагийг илэрхийлж байна. Монгол шүлгүүдэд хөхөөний дуугаар зуны урин дулааныг дүрсэлсэн жишээ элбэг тохиолдоно. Энэ тайлбарыг асуулт хариулт маягаар ойлгуулахдаа хөвчид уянгалж буй хөхөөний донгодох чимээг тусгайлан бэлтгээд оюутнуудад сонсгож болох юм. Мөн монгол шүлгийн уламжлалд байгаль, бодит ахуй байдлыг дүрслэхийн сацуу түүнтэй адилтгаж үлгэрлэн хүний аливаа сайн муу явдлыг өгүүлэх зүйрлэлийн арга түгээмэл байдгийг оюутанд ойлгуулаад “Хөрсөн өндөг бүлээцнэ” гэсэн үгийн учрыг хэлэлцэнэ. Хөхөө шувуу өөрийн өндгийг намнаахай хэмээх бяцхан шувууны үүрэнд орхидог. Хөхөө шувуу яагаад үүр барьдаггүй, үр зулзагаа өөрөө өсгөдөггүй болсон тухай монгол ардын домог байдаг. Тэгвэл энэ шүлэгт тэрхүү домгийн сэтгэлгээний хэлийг ашигласан ажээ. Магадгүй хүйтэн уур амьсгалыг халсан найртай зохистой үг хүний сэтгэлийг бүлээцүүлнэ г.м хүмүүсийн харилцааг илтгэсэн далд утга байж болохыг үгүйсгэх аргагүй.

Хөсөг тэрэг

Хөглөрсөн намар дундуур зүтгэнэ

Уулс бууралтжээ /Т.Дашбалдан/

Энэ шүлэгт нүүдэлчин малчдын амьдралыг дүрсэлсэн болохыг таниулна. Монголын малчид малаа суурин газар байдаг фермерүүд шиг хашаа хороонд өсгөж, тэжээдэггүй. Тэд бэлчээрт малаа идээшлүүлдэг учир жилдээ нутаг сэлгэн нуудаллэдэг. Иймд малчин өрх айл бүр өөр өөрийн хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөтэй байдгийг энэ шүлгийг тайлбарлах явцад таниулж болно. Ингэхдээ говь газрын малчид ихэвчлэн тэмээнд ачилга ачиж нүүдэг бол хангай газрын малчид ихэнхдээ хөсөг тэргээр нүүдгийг хэлж өгнө. Гурад дахь мөрт уулс гэдэг үг орсон байгааг ажиглуулж, шүлэгт говь хангай газрын алиныг дүрсэлсэн бэ гэдгийг асуулт хариултын аргаар хэлэлцэж болно. Шүлгийн тайлбарлахдаа хөсөг тэргээр нүүдэллэж буй зураг ашиглавал хичээлийг сонирхолтой, өгөөжтэй болгоно. Ингэхдээ уран зураг ашиглах нь илүү тохиромжтой юм. Хөглөрсөн гэдэг үгийн утгыг толь бичиг ашиглан мэдүүлсний дараа яагаад чухам хөглөрсөн гэж бичсэний учрыг хэлэлцэнэ. Намрын сүүлч болох хирд модны навч унаж, өвс ургамал хагдран хангай хээрийн газарт хамхуул болон салхинд хийсэж байдгийг хөглөрөх гэдэг үгээр дүрсэлжээ. Уулс бууралтжээ хэмээх үг намар орой болж, уулаар цан хяруу буусан юм уу, анхны цас хаялсныг дүрсэлсэн байна. Тэгэхээр энэ шүлэгт намаржаанаасаа өвөлжөө рүүгээ нуудаллэж буй малчны нүүдлийг заасан байна. Монгол шүлэгт хүний нас, хүний амьдралыг жилийн дөрвөн улиралтай адилтгасан илэрхийлэл түгээмэл байдаг. Хэрвээ энэ үүднээс авч үздэл, дурдан буй нүүдлийн дүрслэлийн цаана хүн бол байгалийн нэг хэсэг, байгальтай адил зохиолчийн шүлгээ зориулж буй хэн нэгэн хүн насны намраа үдэх тийшээ өтөлж буй гунигтай сэтгэлийн өнгө аясыг илтгэсэн гэж тайлбарлаж болох юм. Шүлэгт мөн зүтгэх гэдэг үгийг сонгон оруулсан нь санаандгүй хэрэг биш агаад, энэ үг амьдралын төлөөх хүний тэмцлийг зааж байна.

Эсгий гэрт

Зул бадамлана

Орчлон харанхуй /А.Далхжав/

Монголчуудын үндсэн сууц болох гэрийн аль хэсэгт нь эсгий байдгийг оюутнаас асууж мэдлэгийг нь бататгаж өгнө. Зул, бадамлах гэдэг хоёр үг монголд бурханы шашин дэлгэрсэнтэй холбоотой үг, бадам цэцгийг бурханы шашинтай холбоотойгоор сайн үйлс дэлгэрэхийн бэлгэдэл болгож үздэг, жирийн малчин ард хэдийд, ямар үед гэртээ зул асаадаг зэргийг хэлж өгнө. Харин гурав дахь орчлон харанхуй гэдэг нь шууд утгаар бодит ахуйг зураглаж ойлговол шөнө дүл харанхуй цагийг зааж байгаа бөгөөд хүний амьдралд шилжүүлсэн далд утгаар ухаарвал хүн хорвоогоос хагацаж одсон гэрэл гэгээгүй, гуниг

харуусал бүхий болсон дүрслэл монгол хүний төсөөлөлд бууж болохыг тайлбарлана. Хүн нас барахад заавал шарилыг хөдөөлүүлэх хүртэл илүү гэрт оруулан зул асааж, өрхийг нь бүтээдэг монгол заншил байдгийг таниулж болно.

Нутгаан санасан би

Нулимс дуссан чулуунаасаа

Ээжийнхээ үнэрийг эрнэ. /С.Билигсайхан/

Энэ шүлгийг ямартай ч хоёр янзаар тайлбарлах боломж байна. Үүнд, алс газар явахдаа монголын эртний заншлаар нутгийнхаа чулууг авч явсан өгүүлэгч эхийнхээ тэнгэрт хальсныг дуулаад нулимс унаган нутгийн чулуугаа харан харан эхээ үгүйлэн гашуудаж буйг дүрсэлсэн байж болох юм. Эсвэл, нутагтаа эргэж ирээд, нэгэнт үгүй болсон эхээ дурсан нулимс унагахдаа, багаас өссөн нутгийн танил үнэрээс ээжийнхээ үнэрийг мэдрэх шиг болж байгаа дүр зураг санаанд буух ажээ. Энэ шүлэгт нүүдэлч малчин ард хэдийнээс нутгаа хайрлаж ирсний нэг илрэл - нутгийнхаа чулууг дээдлэх заншил тусгагджээ. Монголын олон нэртэй зохиолч нутгийн чулууны тухай шүлэг, зохиолдоо өгүүлсэн байдаг талаар оюутнуудад хэлж өгөх нь илүүдэхгүй юм.

Хаалга хүртэл

Навчтай мод байснаа санаж гажна

Хаврын бороо /Т. Дашбалдан/

Энэ шүлэгт киго ашиглаагүй, байгалийн ямар нэг зураглал байхгүй бөгөөд шууд хавар гэсэн улирлын нэрийг бичсэн нь хайц шүлэгт хайкугийн дүрмийг ягшуулан барьдаггүйн жишээ юм. Гэвч монгол нутгийн эрс тэс, хуурай уур амьсгалыг гажсан хаалгаар илэрхийлжээ. Хуурай мод чийг авбал тэлнэ. Хуурай модоор хийсэн хаалга урин цагийн ус чийгэнд тэлбэл гажиж болно. Гажсан хаалга бас Монголд зөвхөн банз модоор л хаалга хийдэг байсан нэгэн үеийн ахуй байдлыг санагдуулна. Энэ шүлгээс мөн хүний амьдралын жамыг өгүүлсэн далд утгыг уншиж болохоор байна. Их зохиолч Д. Нацагдорж нэгэнтээ:

“Холхи нар ойртож хасын цас хайлахад

Хуучин дэлхий халагдаж хамаг юм шинэднэ

Хөрсөн мод цэцэглэж хүүхэд багачууд наадахад

Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санан ...”

хэмээн хамаг байгаль, хүн зон бүхэлдээ сэргэн хөгждөг урин цагийн уур амьсгалаар уншигчийн сэтгэлийг хөгжөөн шүлэглэжээ. Тэгвэл яруу найрагч Т.Дашбалдан эсрэгээр хаврын урин цаг ирэхэд хөгшин хүн залуу зандан явснаа санахдаа, өмнөх шигээ бие, тэнхээ үгүй болсондоо нэгэн адил гуниглан буйг илтгэсэн гэлтэй. Ийм ч учраас “хаалга

хүртэл ...савна” гэдэг ч юм уу, өөр ямар нэг үйл үгийг бус, харин гажих гэдэг үгийг сонгон хэрэглэсэн нь учиртай ажээ.

Ийнхүү богино хэлбэрийн шүлгээр дамжуулан аль болох ойлгомжтой үг хэллэг, хялбаршуулсан аргаар монгол орон, малчдын ахуй, зан заншлыг таниулбал оюутанд сонирхолтой, шинэ мэдлэг ч илүү баттай, үлдэцтэй байх болов уу гэж үзэж байна.

Номзүй

Batkhuuyag, Purevkhuu

2014 “Ego-centered character of haiku”,

<http://shortformpoetryofmongolia.blogspot.jp/2014/06/ego-centered-character-of-haiku.html>

Надалсүрэн, Пүрэвдоржийн

2013 “Монгол хайц шүлэг хэмээх том мөчрийн тухайд”,

http://shortformpoetryofmongolia.blogspot.jp/p/blog-page_8.html

Төвшинзаяа Н.

“Хайку хайц шүлгийн тухай”,

http://shortformpoetryofmongolia.blogspot.jp/p/blog-page_9012.html

2015 “Хайкуны тухай 7 үнэн”,

<http://shortformpoetryofmongolia.blogspot.jp/2015/03/7.html>

Хүрэлбаатар Ү.

2015 “Монгол хайку ба гурамсан сэтгэлгээ”,

<https://www.facebook.com/khurelbaatar.urjin/posts/432178366906971>

Явуухулан, Бэгзийн

1966 “Японы хайку хэлбэрийн шүлгийн тухай”, Б.Явуухулан, Утга зохиолын тухай, Улаанбаатар, 1990, 283-288.

1967 “Япон хайку маягаар бичсэн дөрвөн улирлын шүлэг”, Б.Явуухулан, Түүвэр зохиол, Улаанбаатар, 1985, 293.